

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН, ҮР АШИГ”-Т
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АГГ-2021/06-ШТА-ГА

Дундговь дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторовын
үүргийг түр орлон гүйцэтгэгч
Х.Наранцацрал Утас: 70592439,

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Бэрхсайхан Утас:
7059-3208,

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-6
	Дүрслэлийн товьёг	7-8
Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Наранцацрал	<u>Бүлэг А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөгүй байна.</u>	9-15
	А.1 Аймгийн урт хугацааны бодлогын баримт бичиг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрөнгө оруулалтын талаар хангалттай тусгаагүй байна	9-12
	А.2 Зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.	13
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан	А.3 Зарим ТАХ-ний зураг төслийг боловсруулахдаа зайлигүй шаардлагатай ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг тусгаагүйгээс 89.4 сая төгрөгийн нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан, санхүүжилт олгосон байна.	13-15
Аудитор Ч.Оюунтүлхүүр	<u>Бүлэг Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ТАХ-ний хэрэгжилт хангалтгүй байна.</u>	15-23
	Б.1 Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.	15-17
Гэрээт ажилтан Т.Урангуа	Б.2 Зарим ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.	17-19
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Б.3 Тайлант онд хэрэгжсэн барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байна.	19-22
	Б.4. Барьцаа хөрөнгийн данснаас санхүүжүүлсэн 3 ТАХ-ний 1 ТАХ нь хэрэгжилт дутуу хэвээр байна.	22-23
ХАЯГ:	Дүгнэлт	24
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот	Зөвлөмж	25
	Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал	26
	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	27
	Тайлан баталгаажуулах тушаал	28-30
2021 оны 4 дүгээр сар	Тайлангийн хавсралтууд	31-45

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ЭДЦС	Эрдмийн далай цогцолбор сургууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ГИЦС	Говийн ирээдүй цогцолбор сургууль
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

*Аудит хийх үндэслэл, бүрэн
эрх:*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 19.1 дэх хэсэгт зааснаар “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх;
- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.

*Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:*

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль /тухайн үед мөрдөгдөж байсан/;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Барилгын тухай хууль;
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- ✓ Дундговь аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2016-2020 оны аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр;
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”,
- ✓ Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,

Аудитын хамарсан хүрээ:

ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;

- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”;
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэхээр эрх шилжин ирсэн 23 төсөл арга хэмжээний төлөвлөлт, аймгийн хэмжээнд хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийсэн.

Аймгийн төвд хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг объект дээр нь очиж үзэн, хэмжилт хийж, зураг төсөлтэй тулгалт хийлээ. Ковид-19 цар тахлын улмаас сумдад ажиллах боломжгүй болж, барилга байгууламжийн ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгаагүй болно.

Аудитад улсын төсвөөс 2020 онд санхүүжүүлсэн, төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжин хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын 23 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Наранцацрал хянан удирдаж, үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Ч.Бэрхсайхан, аудитор Ч.Оюунтүлхүүр, гэрээт ажилтан Т.Урангуа нар 2021 оны 3 дугаар сарын 15-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийг дуустал хугацаанд аудитыг гүйцэтгэлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Дундговь аймгийн хэмжээнд 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 37,932.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсөв батлагдсан байна.

Үүнээс 14,846.3 сая төгрөгийн 23 ТАХ нь эрх шилжин ирсэн, 23,086.1 сая төгрөгийн 8 ТАХ нь эрх шилжин ирээгүй байна. Эрх шилжин ирсэн ТАХ-ний хувьд 2020 онд 4,101.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Эрх шилжин ирсэн 23 ТАХ-ээс барилга 7, зам гүүр 3, тохижилт, их засварын ажил 9, автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэлтийн 4 ажил байна. Сайдын багцаар авч үзвэл тайлант онд хэрэгжүүлсэн нийт ТАХ-ний 44 хувийг БШУС-ын багц, 56 хувийг бусад сайдын багцаас санхүүжүүлсэн байна.

Тайлант хугацаанд хэрэгжих нийт 23 төсөл, арга хэмжээний 10 нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжсэн, 13 нь шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээ бөгөөд үүнээс 2 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжинэ.

Зургийн товьёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Зураг 1</i>	<i>Цэцэрлэгийн барилгын насжилт</i>	<i>10</i>
<i>Зураг 2</i>	<i>Засварлах шаардлагатай сургуулийн барилга</i>	<i>12</i>
<i>Зураг 3</i>	<i>Сайнцагаан сумын “Хүмүүнлэг” сургуулийн тааз нурсан байдал</i>	<i>12</i>
<i>Зураг 4</i>	<i>Үнэлгээний хороо байгуулсан хугацаа хэтрэлт</i>	<i>15</i>
<i>Зураг 5</i>	<i>Сайнцагаан сумын 1-р цэцэрлэгийн 2-р давхарт барилгын цууралт үүссэн байдал</i>	<i>19</i>

График товьёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>График 1</i>	<i>Цэцэрлэгийн хүчин чадлын хэтрэлт</i>	<i>10</i>
<i>График 2</i>	<i>Сургуулийн хүчин чадлын хэтрэлт</i>	<i>11</i>
<i>График 3</i>	<i>Сургуулийн барилгын насжилт</i>	<i>11</i>

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсөв батлагдсанаас хойш зураг төсөл хийлгэсэн төсөл арга, хэмжээний жагсаалт	13
Хүснэгт 2	Зураг төсөвт багтаагүй боловч нэмэлтээр гүйцэтгэсэн ажил	13
Хүснэгт 3	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн хоног	14
Хүснэгт 4	Тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл	16
Хүснэгт 5	Тайлант онд олгогдох санхүүжилтээс дээд шатны төсөвт төвлөрүүлсэн ТАХ	20
Хүснэгт 6	Гүйцэтгэлийн баталгаа байриуулсан, байриуулах шаардлагатай ТАХ	21

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, урт хугацааны хөгжлийн бодлого стратеги төлөвлөгөөтэй уялдсан байдал	31-33
Хавсралт 2	Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн тоо	34
Хавсралт 3	Сургуульд хамрагдаж буй хүүхдийн тоо	35
Хавсралт 4	Төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэсэн хоногийн судалгаа	37
Хавсралт 5	Эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Үнэлгээний хорооны хугацаа/ судалгаа №1	37-38
Хавсралт 6	Эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Тендерийн хугацаа / судалгаа №2	39-40
Хавсралт 7	Эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Гэрээ байгуулах хугацаа / судалгаа №3	41-42
Хавсралт 8	Нэмэлт гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний судалгаа / гэрээ сунгасан хугацаагаар/	43
Хавсралт 9	Гэрээний хугацаанд хэрэгжээгүй төсөл арга, хэмжээний судалгаа	44-45



БҮЛЭГ А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөгүй байна.

**А.1 Аймгийн урт хугацааны бодлогын баримт бичиг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт
хөрөнгө оруулалтын талаар хангалттай тусгаагүй байна.**

***Тайлант онд хэрэгжсэн ТАХ-ний 61 хувь нь аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого,
стратеги төлөвлөгөөтэй нийцээгүй байна.***

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд нийт 14,846.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 14,476.3 сая төгрөгийн 19 ТАХ нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй болон 2016-2020 оны Засаг даргын мөрийн хөтөлбөртэй нийцсэн боловч 7,465.0 сая төгрөгийн 14 ТАХ нь аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй, 370.0 сая төгрөгийн 4 ТАХ нь Засаг даргын мөрийн хөтөлбөртэй тус тус нийцээгүй байна. /Хавсралт 1/

Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6.4¹ -д заасныг зөрчиж байна.

Эдгээр асуудалд өмнөх жилийн аудитад зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд энэ нь аймгийн урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлогогүй, нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ үр дүнгүй хэрэгжих, хэрэгцээ шаардлагатай асуудалд чиглэгдэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Иймд аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж, түүнд үндэслэн жил бүрийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөж байх шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо барилгын насжилт, чанар, хүртээмж, хүн ам, нийгэм эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулж төлөвлөхгүй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 106 ТАХ-г хэрэгжүүлэх санал ирснийг холбогдох яамдад хүргүүлснээс 13 ТАХ батлагдаж ирсэн байна.

Аудитын явцад ТАХ-г цахим системээр эрэмбэлсэн материалтай танилцахыг хүсэхэд системийн ажиллагааны алдаатай байдлаас шалтгаалан, холбогдох материалыг үзэх боломжгүй байсан бөгөөд энэ асуудал 2019 онд тулгарч байсан.

Энэ нь ТАХ-г цахим системд оруулахдаа санал авах, эрэмбэлэх явцыг баримтжуулж авахгүй байгаатай холбоотой байна.


¹ /Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах зарчмыг баримталж холбогдох тайлан материалыг хавсарна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал;
- Тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэл болон үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал;
- Хэрэгцээ шаардлага үндэслэл;
- Мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
- Төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;
- Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл

Аудитаар эрх шилжин ирсэн ТАХ-ний 44% буюу дийлэнх хувийг БШУС-ын багц эзэлж байгаа тул цэцэрлэг, сургуулийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор барилгын хүчин чадал, суралцагчдын тоо, ачааллыг судалж үзэхэд 4 ерөнхий боловсролын сургууль, 2 цэцэрлэгийн барилгын ашиглалтын хугацаа дууссан байна. Судалгааг дараах байдлаар харууллаа. Үүнд:

Цэцэрлэгийн хувьд: 2020 оны байдлаар төрийн өмчийн 22 цэцэрлэгийн нийт суурилагдсан хүчин чадал 2600 хүүхэд хүлээн авах боломжтой. Харин цэцэрлэгт хамрагдахаар бүртгүүлсэн нийт хүүхдийн тоо 3147 ба цэцэрлэгүүдийн нийт ачаалал 21%-ийн хэтрэлттэй байна. /Хавсралт 2/

График 1



2020 онд аймгийн хэмжээнд төрийн өмчийн 3 цэцэрлэг нь хүчин чадлын хэмжээнд хүүхэд элсүүлсэн, үлдсэн 19 цэцэрлэг нь хүчин чадлаас 10-50%-иар илүү хүүхэд элссэн буюу ачаалал хэтрэлттэй байна.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 8 цэцэрлэг 1025 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай боловч цэцэрлэгт нийт 1412 хүүхэд хамрагдаж, ачаалал хэтрэлт 38% байгаа нь бусад цэцэрлэгүүдтэй харьцуулахад хамгийн өндөр байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт цэцэрлэгүүдээс 50-аас дээш жил ашигласан, ашиглалтын хугацаа дууссан 2, 36-46 жил ашигласан 2, ашиглалтад ороод 21-35 жил болж байгаа 7, 11-20 жил болж байгаа 3 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бол 10 хүртэлх жилийн ашиглалттай 11 цэцэрлэг байна.

Зураг 1 / Цэцэрлэгийн барилгын ашиглалтын хугацаа /



Үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэгийн барилгуудын 50 орчим хувь нь сүүлийн 10 жилд баригдсан, шинэ барилгууд байна. Харин Сайнцагаан сумын хувьд ачаалал хэтрэлт бусад сумдтай харьцуулахад хамгийн өндөр байгаа, 40-өөс дээш жил ашигласан, ашиглалтын хугацаа дууссан барилгын тоо олон, мөн 0-5 насны хүүхдийн тоо сүүлийн 10 жилийн дунджаар 5%-аар өссөн үзүүлэлттэй байгаа зэрэг нь Сайнцагаан суманд шинээр цэцэрлэгийн барилга барих хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Сургуулийн хувьд: Аймгийн хэмжээнд 6-18 хүртэлх насны нийт 10451 хүүхэд байна. 2020-2021 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй 19 төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын барилгын нийт суурилагдсан хүчин чадал 8544 хүүхэд хүлээн авах боломжтойгоос 8496 хүүхэд хүлээн авч аймгийн хэмжээнд сургуулийн барилгын нийт хүчин чадлын ашиглалт 99%-тай байна. /Хавсралт 3/

График 2




График 2-оос харахад Сайнцагаан сумын Цэгц билиг сургуулийн ачаалал хэтрэлт хамгийн өндөр буюу 105%, ЭДЦС 60%, Хүмүүнлэг 49%, Эрдэнэдалай сумын ахлах сургууль 25%-ийн хүчин чадлын хэтрэлттэй ажиллаж байгаа бол Өлзийт сумын дунд сургуулийн хүчин чадлын ашиглалт - 50% буюу ашиглагдаагүй хүчин чадал хамгийн өндөр үзүүлэлттэй, Хулд, Луус, Говь-Угтаал, Өндөршил сумын сургуулиудын ашиглагдаагүй хүчин чадал 33-47% байна.

Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумын хичээлийн 2-р байр, ГИЦС-ийн хичээлийн А байр, Хүмүүнлэг сургуулийн хичээлийн барилга 50-аас дээш жил ашиглаж ашиглалтын хугацаа дууссан, 41-50 жил болж байгаа 5 сургууль, 31-40 жил болж байгаа 7 сургууль, 21-30 жил ашигласан 1 сургууль байгаа бол 1-10 жил ашигласан 7 сургууль байна.

График 3



Мөн аудитаар сургуулиудын барилгын чанар, шаардлагатай засварын талаар судалгаа хийхэд Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн барилгын чанар, төлөв байдлын дүгнэлт гарсан 3 барилга байна. Судалгааг дараах байдлаар харууллаа. Үүнд:

Сургуулиудын барилгуудад тулгамдаж буй засварлах шаардлагатай ажлын төрлөөр ангилбал гадна фасад хуучирч муудсан 19, дотор цахилгааны гэмтэлтэй 15, дээврээс ус гоождог 14, сантехник засварлах шаардлагатай 16, гадна цахилгааны гэмтэлтэй 9, барилгын дотор засал муу 18 сургууль байна.

Зураг 2



Гадна фасад хуучирч
муудсан- 19



Дээврээс ус
гоождог- 14



Барилгын дотор
муудсан- 18



Гадна цахилгаан
гэмтэл их- 9



Дотор цахилгаан
гэмтэл их- 15



МХГ-ын
дүгнэлттэй- 3



Сантехник эвдэрч
хуучирсан- 16

Харин 2016-2018 онд барилга байгууламжид тавигдах шаардлага, ашиглалтын хэвийн нөхцөл найдвартай ажиллагааг хангахгүй болсон тухай Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн барилгын чанар, төлөв байдлын дүгнэлт гарсан Сайнцагаан сумын ГИЦС-ийн хичээлийн А байр, Хүмүүнлэг сургуулийн хичээлийн байр, Сайхан-Овоо сумын сургуулийн хичээлийн байранд одоо болтол хичээл, сургалтын үйл ажиллагаа явагдсаар байна.

Зураг 3 / Хүмүүнлэг сургуулийн тааз нурсан байдал/



сургуулиудтай холбоотой хийгдэх ажлын төсөв тусгагдаагүй байна.

Төрийн өмчийн 19 сургуулийн барилгуудад сүүлийн 10-20 жилийн дотор их засвар хийгдсэн 5 сургууль, сүүлийн 9 жилийн дотор их засвар хийсэн 7 сургууль байгаа бол Эрдэнэдалай сумын хичээлийн А, В байр, Дэлгэрцогт сумын бага сургууль, Говь-Угтаал, Сайхан-овоо сумын сургууль, Сайнцагаан сумын ГИЦС зэрэг сургуулиуд ашиглалтад орсноос хойш их засвар огт хийгдээгүй байна. Эдгээр сургуулийн барилгуудаас Сайнцагаан сумын ГИЦС, Сайхан-Овоо сумын Сургуулийн барилгууд шинээр баригдахаар 2021 оны улсын төсөвт тусгагдсан бол бусад

Иймд аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон тухайн салбарын үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, барилга, байгууламжийн чанар, насжилт, хүчин чадал зэргийг тооцон үзэж хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөж байх шаардлагатай байна.



А.2 Зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 1

№	Төсөл, арга хэмжээний нэр	Зураг төсөл хийгдсэн он
1	Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн их засвар	2020.06 сар
2	Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн барилгын засвар	2020.01 сар
3	Дотуур байрны дээврийн засвар /Дундговь, Дэлгэрцогт сум/	2020.03 сар
4	Сайнцагаан сумын 5-р цэцэрлэгийн барилгын засвар	2020
5	Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн их засвар	2020

Тайлант онд аймагт шинээр эрх шилжин хэрэгжүүлсэн барилгын их засварын 8 ажлаас 3 ажлын зураг төсөл нь төсөв батлагдахаас өмнө хийгдэж, 2 ажил буюу Сайнцагаан сумын 5-р Цэцэрлэгийн барилгын засвар, Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн их засварын ажлын зураг төсөл нь төсөв батлагдахаас өмнө хийгдээгүй бол үлдсэн 3 ТАХ-ний хувьд зураг төсөл нь төсөв батлагдахаас өмнө хийгдсэн боловч зураг төслийн шаардлага хангаагүй тул 2020 онд буюу төсөв батлагдсанаас хойш дахин

шинээр боловсруулсан байна.

Энэ нь зураг төслийг анх боловсруулахдаа хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, объект дээр бодит хэмжилт хийгээгүй, зураг төсөл боловсруулах норм дүрэм баримтлаагүйгэй холбоотой байна.

Тус асуудал нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²-д заасныг зөрчсөн.

ТЭЗҮ, тооцоо судалгаа нь бодитой хийгдсэн, зураг төслийн шаардлага хангасан зураг төсөлтэй ТАХ-г төсөвт тусгаж байх талаарх зөвлөмжийг ТЕЗ нарт хүргүүлэхээр ҮАГ-т уламжилж байна.

А.3 Зарим ТАХ-ний зураг төслийг боловсруулахдаа зайлиггүй шаардлагатай ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг тусгаагүйгээс 89.4 сая төгрөгийн нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан, санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 2 / Зурагт төсөвт ороогүй нэмэлтээр гүйцэтгэсэн ажил /

№	ТАХ-ний нэр	Нэмэлт санхүүжилт	Нэмэлт ажил
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Дундговь, Гурвансайхан сум/	10.5	Гадна холбоо дохиолол
2	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Дундговь, Өндөршил сум/	66.2	Худгаас ус татах, төмөр хашаа
3	Эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Адаацаг/	12.7	Халаах хэрэгсэл шинээр тавьсан.
Нийт		89.4	

Гурвансайхан сумын ЗДТГ-ын барилгын ажлын зураг төсөвт гадна холбоо дохиолол, тохижилт, интернэт болон суурин утас суурилуулах 10.5 сая төгрөгийн ажил багтаагүй байсныг ашиглагч байгууллагын саналаар нэмүүлж, санхүүжилт олгосон байна.

Өндөршил сумын Цэцэрлэгийн барилгын ажлын зураг төсөлд цэвэр усыг төвлөрсөн цэвэр усны худгаас татахаар тусгагдсан байсан боловч гүний худгаас цэвэр ус татахаар болсон тул тус

² /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана./

ажилтай холбоотой 66.2 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны /хуучин нэрээр/ Хөрөнгө оруулалтын газрын албан тушаалтнуудын хурлын тэмдэглэлийг үндэслэн санхүүжилт олгосон байна.

Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлын халаах хэрэгслийн 50%-ийг солих, хуучин радиаторыг угаах угсрахаар төсөвт тусгасан боловч сольж ашиглах боломжгүй шалтгаанаар 12.7 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр халаах хэрэгсэл болон ус гоождог дээврийг засварлах ажил гүйцэтгэсэн байна.

Эдгээр асуудал нь зураг төслийг боловсруулахдаа бодит хэмжилт, тооцоо судалгааг хангалттай хийдэггүй, ашиглагч байгууллага өөрсдөө хариуцан зураг төслөө хийлгэдэг боловч хийгдэх ажлын талаар саналаа бүрэн тусгуулдаггүй, техникийн нөхцөл олгож буй мэргэжлийн байгууллагуудын албан тушаалтны ажлын хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

Иймд мэргэжлийн байгууллагуудад зураг төсөл боловсруулахдаа объект дээр бодит хэмжилт хийн, ашиглагч байгууллагын саналыг авч, тооцоо судалгаа хийж байх, техникийн нөхцөл олгохдоо барилгын норм, дүрэм стандартад нийцсэн дүгнэлт гаргаж, хариуцлагатай ажиллах талаар чиглэл өгч, хяналт тавин ажиллаж байх шаардлагатай байна.

Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлж байх хугацаатай албан шаардлагыг аймгийн Засаг Даргад хүргүүлж байна.

Мөн худалдан авах ажиллагаа зохион байгуулсны үр дүнд бий болсон төсвийн үлдэгдлийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2³-т заасныг зөрчиж байна.

ТАХ-ны барилгын ажлын гүйцэтгэх хугацааг ажлын цар хүрээ, онцлог шинж чанарт үндэслэн оновчтой тодорхойлоогүй байна.

Хүснэгт 3 / ТАХ-г гүйцэтгэсэн хоног /

Д/д	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Ажил гүйцэтгэх хоног
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Дундговь, Гурвансайхан сум/	1,200.0	541
2	Дотуур байрын барилга, 80 ор /Дундговь, Луус сум/	973.0	438
3	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Дундговь, Өндөршил сум/	1,000.0	462
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум/	1,558.0	295
5	Сургуулийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	400.0	450
6	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	300.0	448

Сайнцагаан сумын 150 орны хүчин чадалтай 1,558.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1-р цэцэрлэгийн барилгын ажлыг 295 хоногт гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байхад “Өлзийт сумын сургуулийн их засвар”-ын 400.0 сая төгрөгийн ажлыг 450 хоногт, “Өлзийт сумын цэцэрлэгийн их засвар”-ын 300.0 сая төгрөгийн барилгын их засварын ажлыг 300 хоногт буюу шинээр баригдах барилгын ажлаас илүү хугацаанд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна. /Хавсралт 4/

Энэ нь ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа ажлын цар хүрээ, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийгээгүй, мөн тендер шалгаруулалтад хугацаа алдаж

³ 45.2.Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ;

45.2.3.хөрөнгө оруулалтын худалдан авах үйл ажиллагааны үед нэгжид ногдох өртөг, үнэ, тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл;

гэрээг оройтож байгуулсан зэргээс шалтгаалсан байна. /Хавсралт 8/

Иймд ажил гүйцэтгэх гэрээний хугацааг тооцохдоо тухайн ажлын цар хүрээ, хүндрэл
бэрхшээл, төвөгтэй байдал зэргийг тооцон үзэж байх шаардлагатай байна.



БҮЛЭГ Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ТАХ-ний хэрэгжилт хангалтгүй байна.

Б.1 Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.



ТАХ-г хэрэгжүүлэх боломжтой хугацаанд эрхийг шилжүүлсэн боловч зарим ТАХ-ний
тендер шалгаруулалт зохион байгуулахдаа хугацаа алдсан байна.

Дундговь аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 14,846.3 сая төгрөгийн
төсөвт өртөгтэй 23 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжин
ирсэн байна.


Үүнээс 13,261.0 сая төгрөгийн 10 ТАХ нь өмнөх онд, 1,585.3 сая төгрөгийн 13 ТАХ нь 2020
оны эхний улиралд буюу хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

ТАХ-ны хэрэгжих хугацааны хувьд тайланд онд хэрэгжих 11 ТАХ, он дамжин хэрэгжих 2
ТАХ байна. Нийт 13 ТАХ-ний хувьд эрх шилжин ирсэн хугацаанаас хойш 30-аас дээш хоногийн
дараа үнэлгээний хороо байгуулж хугацаа алдсан байна. /Хавсралт 6/

Зураг 4

ХАА-нд мөрдсөн хугацааны талаар:

Үнэлгээний хороо байгуулахаар төлөвлөсөн хугацаа болон
байгуулсан хугацааг харьцуулан үзэхэд төлөвлөсөн хугацаанд
багтаж үнэлгээний хороо байгуулагдсан 1 ТАХ, төлөвлөгөөнөөс 5-
20 хоногийн хэтрэлттэй 8 ТАХ, 21-100 хоногийн хэтрэлттэй 3 ТАХ
байна.




Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн их засварын ажлыг 2020.03.05-ны өдөр
үнэлгээний хороо байгуулахаар төлөвлөсөн боловч 2020.06.11-ны өдөр үнэлгээний хороо
байгуулагдаж нийт 98 хоног, Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд
дэмжлэг үзүүлэх ТАХ нь 2020.05.25-ны өдөрт үнэлгээний хороо байгуулах төлөвлөгөөтэй байсан
боловч 2020.08.25-ны өдөр үнэлгээний хороо байгуулагдаж нийт 92 хоногийн хугацааны хэтрэлттэй
байна. /Хавсралт 5/

Тендер зарлахаар төлөвлөсөн хугацаанаас 1-10 хоногийн дараа тендер зарласан 5 ТАХ, 11-
50 хоногийн дараа тендер зарласан 5 ТАХ, 51-100 хоногийн дараа тендер зарласан 3 ТАХ байна.
/Хавсралт 6/

Бүх ТАХ-ний тендер хүлээж авах эцсийн хугацаа нь хуульд⁴ заасан шаардлагын дагуух
хугацаанд тендерийн баримт бичиг хүлээн авсан байна. Мөн тендер зарцуулсан нийт хугацаа нь
тендерийн хүчинтэй хугацаанд үнэлгээний хорооны дүгнэлт гарсан байна.

⁴ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24.3 Нээлттэй
тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.



Гэрээ байгуулах эрх олгох хугацаа болон төлөвлөсөн хугацаатай харьцуулан судлахад төлөвлөснөөс 10-40 хоногийн хугацаа хэтрэлттэй 9 ТАХ, 50-100 хонгийн хугацаа хэтрэлттэй 4 ТАХ байна. /Хавсралт 7/

Төлөвлөсөн хугацаанаас 5-20 хоногийн дараа тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулсан байна.

Энэ нь ХАА зохион байгуулах хугацааг төлөвлөхдөө тухайн ТАХ-ны цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзан үзэлгүй бүх ТАХ-г ижил цаг хугацаанд төлөвлөсөнтэй холбоотой байна.

Иймд ХАА-нд мөрдөх хугацааг төлөвлөхдөө ТАХ-ний цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзан үзэж байх, төлөвлөгөөний дагуу ХАА-г зохион байгуулж байх шаардлагатай байна.



Тайлант онд нийт 13 ТАХ-ээс 6 ТАХ-ний ХАА-нд нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэж, 5 тендер амжилттай болж 1 тендер буюу Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх тендер амжилтгүй болсноор, дахин тендер шалгаруулалт зохион байгуулж тендер амжилттай болсон. Харин 7 ТАХ-ны ХАА-нд харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт зохион байгуулж бүгд амжилттай болсон байна.

Хүснэгт 4 /сая төгрөг/

Нийт төсөл арга хэмжээ		Нээлттэй тендер шалгаруулалтын арга хэрэглэсэн төсөл, арга хэмжээ				Тендер амжилтгүй болж дахин тендер зарласан	
Тоо	Дүн	Амжилттай		Амжилтгүй		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн		
13	1,585.3	12	1,335.3	1	250.0	1	250.0

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар "Дэрэн сумын соёлын төвийн барилгын их засвар"-ын 93.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил боловч БСШУС-ын сайдын 2020 оны А/64 дугаартай тушаалаар "Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймагт зохион байгуулах эрх"-ийг нэгдүгээр хавсралтаар 95.0 сая төгрөгөөр баталж тендер шалгаруулалт зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4⁵-т -т заасныг зөрчиж байна.

"Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгын засвар"-ийн 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, "Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж " -ийн 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барааны нийлүүлэх тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгааг шаардах ёстой боловч тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх шаардлагагүй гэж тусган тендер шалгаруулалт зохион байгуулсан байна.

⁵ 46.1.4-т /худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;./

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дүгээр зүйлийн 43.4⁶-т заасныг тус тус зөрчиж байна.

“Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн их засвар”-ын ажлын тендерийн баримт бичигт инженер техникийн ажилтнуудын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг ирүүлэхээр заасан боловч 2 инженер, техникийн ажилтны нийгмийн даатгалын хуулбарыг ирүүлээгүй байхад тендерт оролцогч “Одда тайж” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон байна. Тус тендерт оролцогч “Цаст оргил констракшн” ХХК-ийн ирүүлсэн тендерээс 1 инженер техникийн ажилтны нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг ирүүлээгүй үндэслэлээр татгалзсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1⁷-т заасныг тус тус зөрчиж байна.

Худалдан авах ажиллагааг батлагдсан төсвийн хүрээнд хууль, журмын дагуу зохион байгуулах, тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангасан компанийг шалгаруулж байх талаар аймгийн Засаг даргад хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Б.2 Зарим ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.

Эрх шилжин ирсэн 23 ТАХ-ээс 5 ТАХ нь он дамжин хэрэгжихээр, 18 ТАХ нь тайлант онд хэрэгжихээр төлөвлөгдсөн боловч 13 ТАХ нь гэрээний хугацаандаа хэрэгжиж, 5 ТАХ хугацаандаа хэрэгжээгүй байна. Хугацаандаа хэрэгжсэн 13 ТАХ-ний 5 ТАХ нь нэмэлт гэрээ байгуулан хугацааг сунгасан байна.



Нэмэлт гэрээ байгуулан хугацаа сунгасан ТАХ:

“Сайнцагаан сумын 150 ортой 1-р цэцэрлэгийн барилга”; “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”-ын ажлын зураг төсөл нь төсөв батлагдсанаас хойш хийгдсэн */бүлэг А.2-оос харна уу/*, зарим ажлыг тооцоо судалгаагүй төсөвлөснөөс зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлагатай болсон зэргээс шалтгаалж гэрээний хугацааг сунгасан байна.

“Адаацаг сумын ЭМТ-ийн барилгын их засвар”, “Өндөршил сумын цэцэрлэгийн барилга”-ын ажлын зураг төсөлд тусгаагүй болон ажлын тоо хэмжээ дутуу боловч зайлшгүй хийх шаардлагатай ажлуудыг гүйцэтгэхэд хугацаа шаардлагатай болсон тухай гүйцэтгэгчийн ирүүлсэн хүсэлтээр гэрээний хугацааг сунгасан байна.

“Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам-Сайнцагаан сум 2,8 км”, “Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засвар”-ын ажлыг гүйцэтгэгч компанийн хүсэлтээр гэрээний хугацааг сунгасан байна.

“Наадмын талбайн барилгын дуусгал”, “Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын барилга”, “Луус сумын дотуур байр 80 ортой барилга”-ын ажил нь Ковид -19 цар тахал гарсантай

⁶ 43.4. Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана:

43.4.1. 150 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил худалдан авах гэрээ байгуулах;

43.4.2. 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах;

43.4.3. хоёр жилээс дээш хугацаагаар үргэлжлэх худалдан авах гэрээ байгуулах

⁷ 27.1. Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараахь шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ: 27.1.3. тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага. 27.3. Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ. 27.4. Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана./

холбогдуулан бараа материалын тээвэрлэлт хойшилсон болон цементийн үнийн өсөлтөөс шалтгаалж гэрээний хугацааг сунгасан байна.



Гэрээний хугацаанд хэрэгжээгүй ТАХ:

“Луус сумын дотуур байр 80 ортой барилга”, “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто зам-2.8 км”, “Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засвар”, “Говь-Угтаал сумын спорт заалны барилга”, “Аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх” зэрэг ТАХ нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй байна.

Эдгээр асуудал нь ХАА зохион байгуулах, гэрээ байгуулах зэрэгт хугацаа алдсан, захиалагч гэрээний хугацааг бодитой зөв тооцоолоогүй, COVID-19 цар тахал болон гүйцэтгэгч байгууллагын хариуцлагагүй байдал зэргээс шалтгаалсан байна.

Мөн нэг компани хэд хэдэн тендерт шалгарч тэдгээр ажлуудыг нэг цаг хугацаанд гүйцэтгэснээр ажиллах хүч, машин механизм, тоног төхөөрөмжийн дутагдалтай байдлаас шалтгаалан гэрээний үүргээ хугацаандаа биелүүлэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Тухайлбал:

“Одда тайж” ХХК тайланд онд “Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар”, “Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгын их засвар”, “Дэлгэрцогт сумын Соёлын төвийн барилга”-ын ажлын нийт 3 ТАХ-ны 1,495.2 сая төгрөгийн ажлыг давхар гүйцэтгэхээр гэрээг байгуулсан боловч хэрэгжсэн ажил одоогоор байхгүй байна. Мөн тус компани нь 2018 онд “Цагаандэлгэр сумын халуун ус, ахуй үйлчилгээний барилгын ажил”-ын гүйцэтгэлээс илүү санхүүжилт авсан ба 2019 онд Төрийн аудитын байгууллагаас албан шаардлага хүргүүлсэн. “Өлзийт сумын ЭМТ-ийн барилгын их засвар” - ын ажлыг гүйцэтгэхдээ ашиглагч байгууллагын хүсэлтээр өөр ажил гүйцэтгэсэн боловч ажлын бодит гүйцэтгэлээс 3.9 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон боловч одоог хүртэл төлөөгүй байна.

“Бум консракшн” ХХК нь 2020 онд “Ахмадын өргөөний барилга /Сайнцагаан сум/”, “Говь-Угтаал сумын Спорт заалны барилга”-ын нийт 2,230.0 сая төгрөгийн ажил болон бусад аймгуудад өөр ажлууд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан, мөн захиалагчаас ажлаа цаг хугацаанд нь гүйцэтгэх талаар удаа дараа шаардлага тавьсан боловч тайлант онд “Говь-Угтаал сумын Спорт заалны барилга”-ын ажлыг огт гүйцэтгээгүй байна.

Тендер шалгаруулалтад оролцож байгаа оролцогч нь тухайн ажилтай ижил цаг хугацаанд өөр ажил гүйцэтгэхээр байгаа бол тус этгээдийн ажиллах хүч, машин механизм болон тоног төхөөрөмж нь тухайн ажлуудыг нэгэн зэрэг гүйцэтгэх боломж нөөцтэй эсэхийг нотолсон баримт ирүүлэх тухай шаардлагыг тендерийн баримт бичигт тусган, тендер шалгаруулалт зохион байгуулж байх талаар зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

Сайн жишээ:

Сайнцагаан сумын 5-р цэцэрлэгийн дээврийн засварын ажлын гүйцэтгэгч “Ашид бюлдинг” ХХК нь орон нутагт харьяалалтай ба аймгаас ажиллах хүчин авч ажиллуулсан, гэрээний хугацаанд ажлыг чанартай гүйцэтгэж, эргэх холбоотой ажилласан ба 9.1 сая төгрөгийн ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн байна.

Чанаргүй гүйцэтгэсэн барилгын ажлууд:

Сайнцагаан сумын 150 ортой Цэцэрлэгийн барилгын 1,558.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэгч “Эйч Ар Ви” ХХК нь гэрээг анх 8 сард байгуулж, барилгын зарим ажлыг өвлийн улиралд гүйцэтгэсний улмаас 2 давхрын ихэнх өрөөнүүдийн хананд цууралт үүссэн байна. Магадлалгүй ажлын зардлаар 1.5 сая төгрөгийн “Ус халаагч” суурилуулсан боловч огт ашиглаагүй, одоогийн байдлаар ажиллахгүй байна.

Зураг 5 /Сайнцагаан сумын 1-р цэцэрлэгийн барилгад цууралт үүссэн байдал/



Иймд Сайнцагаан сумын 1-р цэцэрлэгийн 2-р давхрын өрөөнүүдэд цууралт үүссэн нь эрүүл, аюулгүй байдлын шаардлага хангаж байгаа эсэх талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, тус асуудалтай холбоотой хийгдэх засварын ажлуудыг гүйцэтгүүлэх болон барилгын ажлын явцад суурилуулсан ус халаагчийг ажилд оруулан, хэвийн ажиллагааг хангуулах талаар гүйцэтгэгч компанид үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай хугацаатай албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.



Б.3 Тайлант онд хэрэгжсэн барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байна.

“Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто зам-2.8 км”-ын ажлын гүйцэтгэгч “Анарзоне” ХХК нь ажлыг зураг төслийн дагуу хийгээгүй, барилгын талбайд инженер техник хариуцсан ажилтан байхгүй, бетоны гадаргууд хагарал их үүссэн, авто зогсоолын суурийн нягтруулалт хийхгүй сул хөрс асгаж бетон цутгалт хийсэн, зорчих хэсгийн ус зайлуулах байгууламж хийгдээгүй, хучилтын заадас гаргалгүй цутгасан зэрэг зөрчил дутагдлыг арилгуулахаар ГХБХБГ-аас үүрэг даалгавар өгсөн боловч биелүүлээгүй байна.

“Цагаандэлгэр сумын 240 суудалтай соёлын төвийн барилга”-ын ажлыг гүйцэтгэх явцад бетон цутгалтын ажлыг буруу цэгээс алслалтай дам нурууг эхэлж цутгаснаас дам нурууны хэв хашмал, тулаасын ачаалал хэтэрч эвдрэлд орсноор бусад хийц бүтээцийн арматурчлал, хэв хашмалд нуруулт үүсэх шалтгаан болсон. Тус барилгын ажилд ГХБХБГ-аас зохиогчийн хяналт хийлгэж эвдрэл үүссэн хийц, хэв гажилтад орсон арматурчлалыг цаашид ашиглах боломжтой эсэх талаар дүгнэлт гаргуулсны дараа барилга угсралтын ажлыг цааш үргэлжлүүлэх талаар үүрэг даалгавар өгсөн байна.

Эдгээр асуудлууд нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаартай “Журам шинэчлэн батлах тухай” тушаалын 15.1⁸, “Барилгын тухай” хуулийн 14.1⁹, 14.1.1¹⁰, 14.1.2¹¹, 14.1.3¹², 14.6¹³ дах заалтыг тус тус зөрчиж байна.

2020 онд 23 ТАХ-ны 7,182.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 6 ТАХ-ны 1,667.2 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн ерөнхий дансанд татуулан төвлөрүүлсэн байна.

“Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн их засвар”-ын ажил удаашралтай явагдсан, захиалагчаас гүйцэтгэгчид компанид өгсөн ажил гүйцэтгэх дарааллыг баримтлаагүйгээс хүйтний улиралд хийгдэх боломжгүй гаднах ажил хийгдээгүй үлдсэн зэргээс шалтгаалан 2020 оны санхүүжилтээс 96.4 сая төгрөгийг төсвийн ерөнхий дансанд татуулан төвлөрүүлсэн байна.

“Наадмын талбайн барилгын дуусгал”-ын ажил нь 2020 онд 1,000.0 сая төгрөгийн санхүүжилт авах байсан боловч 22% буюу 530.9 сая төгрөгийн гүйцэтгэл хийгдэж, оны эцэст гүйцэтгэлийг бодит байдлаас зөрүүтэйгээр ХОХБТХэлтэст ирүүлсэн тул буцаагдаж хугацаа алдсанаас 469.1 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн ерөнхий дансанд татуулан төвлөрүүлсэн.

Хүснэгт 5

№	ТАХ-ний нэр	Тайлант онд олгогдох санхүүжилтээс дээд шатны төсөвт төвлөрүүлсэн дүн/сая төг/	“Луус сумын сургуулийн дотуур байрны барилга”, “Аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх” ажлуудад хүлээн авах комисс ажиллаж, дутуу гүйцэтгэсэн ажлуудыг хийлгэхээр комиссын үүрэг даалгавар өгч, 2021 онд гүйцэтгүүлэхээр болсон байна.
1	Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/	469.1	
2	Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал сум/	500.0	
3	Дотуур байрын барилга, 80 ор /Дундговь, Луус сум/	182.3	
4	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/ БАГЦ - 1	556.5	
	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/ БАГЦ - 2		
5	Сумын төвийн эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Баянжаргалан сум/	96.4	
6	Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	9.7	
	Нийт дүн	1,667.2	

“Говь-Угтаал сумын спорт заалны барилга” ажлыг гүйцэтгэж байгаа “Бум констракшн” ХХК, “Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн их засварын барилга”-ын гүйцэтгэгч компани “Одда тайж” ХХК нь олон давхар ажил гүйцэтгэж уг ажил нь хийгдээгүй, 596.4 сая төгрөгийн санхүүжилтийг дээд шатны төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. /Бүлэг 2-оос харна уу/

Дээрх ТАХ-үүдийн дээд шатны төсөвт төвлөрүүлсэн дүн нь 2021 оны төсөвт тусгагдаагүй бөгөөд энэ нь тус ТАХ-үүд дуусахгүй орхигдох, ашиглалтгүй үлдэх эрсдэлийг бий болгож байна.

⁸ 15.1. Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм журам норм стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ.

⁹ 14.1.Барилга байгууламж дараахь шаардлагыг хангасан байна:

¹⁰ 14.1.1.зураг төслийн дагуу баригдсан байх;

¹¹ 14.1.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байх;

¹² 14.3.Барилга байгууламжийг ашиглалтад зугируулх, тохируулах хугацаа нэг жил байна.

¹³ 14.6.Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

Дотоодын давуу эрх тооцуулж тендерт шалгарсан этгээд тендерийн баримт бичигт тавигдсан шаардлагыг биелүүлэн ажиллаж байгаа эсэхэд тавих хяналт хангалтгүй байна.

Тайлант онд 5 ТАХ-ны тендерт оролцогч нь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах гэрээ байгуулан давуу эрх тооцуулсан байна.

“Өлзийт сумын сургуулийн барилгын их засвар”-ын ажлын гүйцэтгэгч “СДММ” ХХК нь тендерт оролцоходоо Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай орон нутгаас 2 тогооч, 8 туслах ажилтан нийт 10 ажилтныг сарын 0.8 сая төгрөгөөр цалинжуулахаар гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгч компани тус шаардлагыг биелүүлээгүй байна.

Тус асуудал нь орон нутгаас ажиллах хүч авах тухай тендерийн баримт бичигт тусгасан шаардлага болон гэрээний биелэлтийг дүгнэдэггүй, хяналт тавьдаггүй, орон нутгаас ажиллах хүчин олддоггүйтэй холбоотой байна.

Энэ нь тендер шалгаруулалтад дотоодын давуу эрхийн зөрүү тооцсон нь бодитой бус байх, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, зорилт биелэгдэхгүй байх үр дагаврыг бий болгож байна. Давуу эрхийн зөрүү тооцож тендерт шалгарсан ч тухай ажлыг гүйцэтгэхдээ орон нутгаас ажиллах хүч авахгүй байх эрсдэлтэй байна.

Иймд дотоодын давуу эрх тооцуулах хүсэлтэй тендерт оролцогч нь орон нутгаас ажиллах хүчин авах боломжтой гэж үзсэн тохиолдолд гэрээ байгуулан, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн баталгаа:

Тайлант онд 1,101.6 сая төгрөгийн гэрээтэй 4 ТАХ 56.2 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа гаргах байснаас Өлзийт сумын сургуулийн барилгын их засвар, Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгын их засвар, Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн их засварын нийт 43.7 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа гаргаж, Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж /Дундговь, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум/ ажил нь 12.5 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гаргаагүй байна.

Дээрх ажлуудын гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа гүйцэтгэлийн баталгааны дүн болон хэлбэрийг гэрээнд тусгаагүй байна.

Хүснэгт 6 /Гүйцэтгэлийн баталгаа гаргах ТАХ-ны жагсаалт/

Төсөл арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв/сая.төг/	Гэрээний дүн	ТББ Гүйцэтгэлийн баталгааг тусгасан эсэх	Гүйцэтгэлийн баталгаа гаргасан эсэх	Гүйцэтгэлийн баталгааны дүн
Сургуулийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	400.0	377.5	Тийм	Тийм	18.9
Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	300.0	278.9	Үгүй	Тийм	15.0
Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж /Дундговь, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум/	250.0	250	Үгүй	Үгүй	12.5
Сумын Эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Баянжаргалан сум/	200.0	195.2	Тийм	Тийм	9.8
НИЙТ ДҮН	1,150.0	1,101.6			56.2

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.3¹⁴-т заасныг зөрчиж байна.

Тайлант онд хэрэгжсэн нийт ТАХ-ны гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6¹⁵-т заасныг зөрчиж байна.

Иймд гэрээ байгуулахдаа гүйцэтгэлийн баталгааны дүн болон хэлбэрийг тусгаж байх, гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналтын явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулж байх албан шаардлагыг аймгийн Засаг Даргад хүргүүлж байна.

Б.4. Барьцаа хөрөнгийн данснаас санхүүжүүлсэн 3 ТАХ-ний 1 ТАХ нь хэрэгжилт дутуу хэвээр байна.

Өмнөх онд хэрэгжиж дуусах ёстой боловч гэрээний хугацааг сунган он дамжуулан хэрэгжүүлэхээр болсон “Сайнцагаан сумын 150 ортой 1-р цэцэрлэгийн барилга”-ын 292.6 сая, “Сайнцагаан сумын наадмын талбайн барилгын дуусгал”-ын 552.8 сая нийт 845.4 сая төгрөгийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд 2019 онд байршуулж, 2020 санхүүжилтийг олгосон боловч “Сайнцагаан сумын наадмын талбайн барилгын дуусгал”-ын ажил дуусаагүй хэвээр байна. /Бүлэг Б.3-аас харна уу/

“Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”-ын ажлын тендер шалгаруулах, гэрээ байгуулах эрх шилжин ирсэн боловч санхүүжилтийн эрх шилжиж ирээгүй тул 2019 онд 87.9 сая төгрөгийг Зам, тээврийн хөгжлийн яамны барьцаа хөрөнгийн дансанд байршуулж 2020 онд санхүүжилт олгосон ба гэрээний хугацаанд хэрэгжиж дууссан байна.

“Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилга”-ын ажил тайлант онд 655.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэж санхүүжилт авах байсан боловч ажлын гүйцэтгэл дутуу учир 486.7 сая төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдэл 186.3 сая төгрөгийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.



Ашиглалтад орсон 3,691.2 сая төгрөгийн барилга байгууламжийг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

Тайланд онд барилга байгууламжийн 3 ажил, барилгын их засварын 5 ажлын нийт 3,961.4 сая төгрөгийн 8 ТАХ хэрэгжиж дууссан байна. Үүнээс 270.2 сая төгрөгийн санхүүжилттэй их засварын 5 ажлыг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

“Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын барилга”, “Өндөршил сумын 200 ортой цэцэрлэгийн барилга” , “ Сайнцагаан сумын 150 ортой цэцэрлэгийн барилга”-ын нийт 3,691.2 сая

¹⁴ 40.3.Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана: 40.3.5.гүйцэтгэлийн баталгаа шаардах бол түүний дүн, хэлбэр;

¹⁵ 46.1.6.гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;

төгрөгийн барилга байгууламжийг Төрийн өмчийн хорооны шийдвэр гараагүй учраас нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

УТХО-аар 351.4 сая төгрөгийн автомашин, 353.0 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг яамдаас хуваарилсныг байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Тайланд онд хэрэгжиж дууссан 5 барилгын ажлаас Сайнцагаан сумын 5-р цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажлыг барилгын хувийн хэрэгт хөтөлсөн бол бусад ажлыг хувийн хэрэгт хөтлөөгүй байна. “Дэлгэрцогт сумын дотуур байрны дээврийн засвар”, “Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн барилгын их засвар”, “Дэрэн сумын соёлын төвийн барилгын их засвар”, “Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн их засвар”-ын ажлыг барилга байгууламжийн хувийн хэрэгт хөтлөөгүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 46.1.2¹⁶, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 2.1¹⁷ дэх заалтыг тус тус зөрчиж байна.

Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумын ЗДТГ-т 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй автомашин нийлүүлэгдэх байсан боловч өмнө нь ОНХСангаас 50 сая төгрөгийн автомашиныг Эрдэнэдалай суманд нийлүүлсэн тул 125.0 сая төгрөгийн автомашиныг аймгийн ЗДТГ авсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаартай “Журам шинэчлэн батлах тухай” тушаалын 9.28¹⁸ дах заалтыг зөрчсөн ба аймгийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хангалтгүй, УТХО болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хоорондын уялдаа холбоо муугаас шалтгаалжээ.

Аймгийн хөрөнгө оруулалтын бодлого төлөвлөлтөд хэрэгжүүлэх ТАХ-ний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусган, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

¹⁶ 46.1.2.энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх

¹⁷ 2.1.Өмчлөгч, эзэмшигч нь барилга байгууламжийг ашиглалтад орох үед түүний хувийн хэргийг нээж хөтлөн эдэлгээний хугацаанд түүнд өргөтгөл, шинэчлэл, их засвар, үзлэг, шалгалт хийсэн, зориулалтыг өөрчилсөн, эвдрэл, гэмтэл, согог гарсан, сервитут тогтоосон, буулгасан тохиолдолд хувийн хэрэгт баяжуулалт хийнэ.

¹⁸ 9.28. Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ҮР ДҮН МУУТАЙ БАЙНА.

Бүлэг А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөгүй байна.

А.1 Аймгийн урт хугацааны бодлогын баримт бичиг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрөнгө оруулалтын талаар хангалттай тусгаагүй байна.

А.2 Зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

А.3 Зарим ТАХ-ний зураг төслийг боловсруулахдаа зайлиггүй шаардлагатай ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг тусгаагүйгээс 89.4 сая төгрөгийн нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан, санхүүжилт олгосон байна

Бүлэг Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ТАХ-ний хэрэгжилт хангалтгүй байна.

Б.1 Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Б.2 Зарим ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.

Б.3 Тайлант онд хэрэгжсэн барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байна.

Б.4. Барьцаа хөрөнгийн данснаас санхүүжүүлсэн 3 ТАХ-ний 1 ТАХ нь хэрэгжилт дутуу хэвээр байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж, түүнд үндэслэн жил бүрийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөж байх.
2. Аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон тухайн салбарын үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, барилга, байгууламжийн чанар, насжилт, хүчин чадал зэргийг тооцон үзэж хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөж байх шаардлагатай байна.
3. Мэргэжлийн байгууллагуудад зураг төсөл боловсруулахдаа объект дээр бодит хэмжилт хийн, ашиглагч байгууллагын саналыг авч, тооцоо судалгаа хийж байх, техникийн нөхцөл олгоходоо барилгын норм, дүрэм стандартад нийцсэн дүгнэлт гаргаж, хариуцлагатай ажиллах талаар чиглэл өгч, хяналт тавин ажиллах.
4. Ажил гүйцэтгэх гэрээний хугацааг тооцоходоо тухайн ажлын цар хүрээ, хүндрэл бэрхшээл, төвөгтэй байдал зэргийг тооцон үзэж байх.
5. Дотоодын давуу эрх тооцуулах хүсэлтэй тендерт оролцогч нь орон нутгаас ажиллах хүчин авах боломжтой гэж үзсэн тохиолдолд гэрээ байгуулан, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Орон нутгийн өмчийн газарт:

6. ХАА-нд мөрдөх хугацааг төлөвлөхдөө ТАХ-ны цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзан үзэж байх, төлөвлөгөөний дагуу ХАА-г зохион байгуулж байх.
7. Тендер шалгаруулалтад оролцож байгаа оролцогч нь тухайн ажилтай ижил цаг хугацаанд өөр ажил гүйцэтгэхээр байгаа бол тус этгээдийн ажиллах хүчин, машин механизм болон тоног төхөөрөмж нь тухайн ажлуудыг нэгэн зэрэг гүйцэтгэх боломж нөөцтэй эсэхийг нотолсон баримт ирүүлэх тухай шаардлагыг тендерийн баримт бичигт тусган, тендер шалгаруулалт зохион байгуулж байх.



Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар зураг төсөл, тооцоо судалгаа хийгдээгүй ТАХ-г төсөвт тусгаж баталсантай холбоотой зөрчил давтан гарсаар байна.

Тухайлбал 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ❖ Зураг төсөл нь төсөв батлагдсанаас хойш хийгдсэн, бодит хэмжилт, хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаанд үндэслэн хийгдээгүй;
- ❖ Зайлшгүй хийх шаардлагатай ажлыг төсөвт тусгаагүй орхигдуулснаас 190.2 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж санхүүжилт олгосон;
- ❖ Батлагдсан ТАХ-ний байршлыг өөрчилсөн, зураг төсөлд тусгасан ажлыг өөрчлөн гүйцэтгэсэн. /Бүлэг Б.4-оос дэлгэрэнгүй харна уу/

Иймд ТЕЗ нарт “ТЭЗҮ, зураг төсөл, тооцоо судалгаа хийгдсэн ТАХ-г төсөвт тусгаж байх, зураг, төслийг бодит хэмжилт, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, зураг, төслийг боловсруулж байгаа гүйцэтгэгч компаниудын ажлын хариуцлагыг өндөржүүлэх талаар зөвлөмж хүргүүлэх” саналыг ҮАГ-т уламжилж байна.



Шалгагдагч байгууллагын санал тайлбар



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум

Утас/факс: 70592895

И-мэйл: info@dundgovi.gov.mn

2021.04.30 № 1/675

танай 2021.04.27 -ны № 01/96 -т

┌ ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 01/96 дугаартай албан бичгээр ирсэн 2020 оны улсын төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцан явцын дунд холбогдох тайлбар материалыг хүргүүлэн ажилласан тул тухайн дүгнэлт, зөвлөмжид өгөх санал байхгүй.

Цаашид судалгаа болон тайлантай танилцах хугацааг тооцон ирүүлэх талаар анхааран хамтран ажиллана уу.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



М. Вэрхсайхан
тайлан оруулж,
аудитын тайланг тухайн
бичгээр хүргүүлэх.
R 5/30

485212/23



Тайлан баталгаажуулах тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 8/68

Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /АГГ-2021/06-ШТА-ГА/-г баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага, зөвлөмж)-ийг хавсралтаар баталсугай.

3. “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2021 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/-д зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор /Ч.Бэрхсайхан / -д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.НАРАНЦАЦРАЛ



0012010030

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудиторын 2021 оны 08 дугаар сарын
30-ны өдрийн 18 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Аудитаар илрүүлсэн зөрчлийн жагсаалт

Аудитын код: АГГ-2021/06-ШТА-ГА


Аудитын нэр: “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг”

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсөн хуулийн заалт	Зөрчлийн дүн сая.төг	Үүнээс				Үр өгөөжийн	
				Аудитын явцад баригдсан	Акт тавигдсан сая.төг	Албан шаардлага өгсөн сая.төг	Зөвлөмжөөр өгсөн сая.төг	Тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулаагүй, түүнд үндэслэн жил бүрийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөөгүй.	“Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6.4	-				-		
2	Аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон тухайн салбарын үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, барилга, байгууламжийн чанар, насжилт, хүчин чадал зэргийг тооцон үзэж хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөөгүй.	“Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.1, 3.6	-				-		
3	Мэргэжлийн байгууллагуудад зураг төсөл боловсруулахдаа объект дээр бодит хэмжилт хийн, шинжлэгч байгууллагын саналыг авч, тооцоо судалгаа хийж байх, техникийн нөхцөл олгохдоо барилгын норм, дүрэм стандартад нийцсэн дүгнэлт гаргаж, хариуцлагатай ажиллах талаар чиглэл өгч, хяналт тавьж ажиллаагүй.	Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.176, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.47	-						
4	Ажил гүйцэтгэх гэрээний хугацааг тооцохдоо тухайн ажлын цар хүрээ, хүндрэл бэрхшээл, төвөгтэй байдал зэргийг тооцоогүй.		-				-		
5	Дотоодын давуу эрх тооцуулах хүсэлтэй тендерт оролцогч нь орон нутгаас ажиллах хүчин авах боломжтой гэж үзсэн тохиолдолд гэрээ байгуулан, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй.		-				-		
6	ХАА-нд мөрдөх хугацааг төлөвлөхдөө ТАХ-ны цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзалгүй, харилцан адилгүй сонгосон		-				-		
7	Тендер шалгаруулалтад оролцож байгаа оролцогч нь тухайн ажилтай ижил цаг хугацаанд өөр ажил гүйцэтгэхээр байгаа бол тус этгээдийн ажиллах хүчин, машин механизм болон тоног төхөөрөмж нь тухайн ажлуудыг нэгэн зэрэг гүйцэтгэх боломж нөөцтэй эсэхийг нотолсон баримт ирүүлэх тухай шаардлагыг тендерийн баримт бичигт тусган, тендер шалгаруулалт зохион байгуулаагүй.		-				-		

8	“Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн их засвар”-ын ажлын тендерийн баримт бичигт заасан шаардлага хангаагүй “Одонтайж” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.3, 27.4	-	-				
9	“Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын засвар”-ийн 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, “Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж” - ийн 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барааны нийлүүлэх тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх шаардлагагүй гэж тусган тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дүгээр зүйлийн 43.4-т 43.4.1, 43.4.2, 43.4.3.	27.5	27.5				
10	“Өлзийт сумын сургуулийн барилгын их засвар”, “Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын их засвар”, “Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн их засвар”-ын ажлын захиалагч нь гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа гүйцэтгэлийн баталгааны дүн болон хэлбэрийг гэрээнд тусгаагүй байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3	43.7	43.7				
11	Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлээгүй.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6	-	-				
12	Сайнцагаан сумын 1-р цэцэрлэгийн барилгын зарим ажлыг өвлийн улиралд гүйцэтгэсний улмаас 2 давхрын ихэнх өрөөнүүдийн хананд цууралт үүссэн. “Ус халаагч” суурилуулсан боловч огт ашиглаагүй, одоогийн байдлаар ажиллахгүй байна.	Сангийн сайдын 2019 оны 282 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжих, хянах, тайлагнах журам”-ын 15.1, “Барилгын тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.6.	1.5	1.5				
13	“Дэлгэрцогт сумын дотуур байрны дэврийн засвар”, “Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн барилгын их засвар”, “Дэрэн сумын соёлын төвийн барилгын их засвар”, “Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн их засвар”-ын ажлыг барилга байгууламжийн хувийн хэрэгт хөтлөөгүй.	Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 2.1	250.2	250.2				
14	3. “Гурвансайхан сумын ЗДТГ-ын барилга”, “Өндөршил сумын цэцэрлэгийн барилга”, “Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар”-ын ажлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг нэмэлт ажил гүйцэтгүүлэн, санхүүжилт олгосон.	Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2	89.4	89.4				
Дүн			412.3	-	-	412.3	-	-

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  Ч.БЭРХСАЙХАН
 АУДИТОР  Ч.ОЮУНТҮЛХҮҮР
 ГЭРЭЭТ АЖИЛТАН  Т.УРАНГУА

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  Х.НАРАНЦАЦРАЛ

Хавсралт 1

2020 ОНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2012-2031 ОНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДСАН БАЙДАЛ

Д/д	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Хөгжлийн бодлого стратеги төлөвлөгөө	Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл	Засаг даргын мөрийн хөтөлбөр
1	Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн засвар	40,000,000	-	6.1.7 Шаардлагатай сумдын цэцэрлэгийн барилгад засвар хийх буюу шинээр барина.	6.2.5.Сайнцагаан сумын 1-р цэцэрлэг болон шаардлагатай сумдад хүүхдийн цэцэрлэгийн барилга барина.
2	Сайнцагаан сумын 5-р цэцэрлэгийн барилгын дээврийн засвар	20,000,000	-	6.1.7 Шаардлагатай сумдын цэцэрлэгийн барилгад засвар хийх буюу шинээр барина.	6.2.5.Сайнцагаан сумын 1-р цэцэрлэг болон шаардлагатай сумдад хүүхдийн цэцэрлэгийн барилга барина.
3	Дэлгэрцогт сумын дотуур байрны дээврийн засвар	27,300,000	3.4.1.4 Сайнцагаан, Сайхан-Овоо, Луус, Адаацаг сумдад дотуур байр барих	6.1.9 Шаардлагатай сумдын сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгад засвар хийх буюу шинээр барина.	6.2.7 Шаардлагатай сумдын сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгад засвар хийх буюу шинээр барина.
4	Сайнцагаан сумын 150 ортой 1-р цэцэрлэгийн барилга	1,558,000,000	3.4.1.2 Баянжаргалан, Өндөршил, Луус, Эрдэнэдалай, Сайнцагаан, Адаацаг, Дэлгэрцогт, Хулд, Өлзийт сумдад цэцэрлэгийн барилга шинээр барих	6.1.7 Шаардлагатай сумдын цэцэрлэгийн барилгад засвар хийх буюу шинээр барина.	6.2.5 Сайнцагаан сумын 1-р цэцэрлэг болон шаардлагатай сумдад хүүхдийн цэцэрлэгийн барилга барина.
5	Соёлын төвийн барилгын их засвар /Дундговь, Дэрэн сум/	93,000,000	3.5.1.2 Сумдад орон нутаг судлах танхим болон номын сан бүхий иж бүрэн цогцолбор соёлын төвийн барилга барих	6.1.10 Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын ажлыг дуусгаж, шаардлагатай сумдад соёлын төвийн барилгыг засварлах буюу шинээр барина.	6.2.8 Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын ажлыг дуусгаж, шаардлагатай сумдад соёлын төвийн барилгыг засварлах буюу шинээр барина.
6	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж /Дундговь, Сайнцагаан сум/	300,000,000	-	6.1.14 Аймгийн төв болон зарим сумдын төвд хатуу хучилттай зам, тохижилт, ногоон байгууламжийг байгуулна.	6.2.12 Аймгийн төв болон зарим сумдын төвд хатуу хучилттай зам шинээр барьж, засварлан явган хүний зам, талбай байгуулна.
7	Эрүүл мэндийн төвийн засварын ажил /Дундговь, Адаацаг сум/	100,000,000	-	6.1.12 Шаардлагатай сумдын нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв барилгад засвар хийх буюу шинээр барина.	6.2.10 Шаардлагатай сумдын эрүүл мэндийн төвийн барилга засварлах буюу шинээр барьж, нэгдсэн эмнэлгийн барилгын сан техникийн засвар, угаалга, моорогийн барилгын их засвар, амбулаторийн барилгын хүүзүүвч, хүлээлгийн танхимыг шинээр барина.

8	100 ортой цэцэрлэгийн барилга /Дундговь, Өндөршил сум/	1,000,000,000	3.4.1.2 Баянжаргалан, Өндөршил, Луус, Эрдэнэдалай, Сайнцагаан, Адаацаг, Дэлгэрцогт, Хулд, Өлзийт сумдад цэцэрлэгийн барилга шинээр барих	6.1.7 Шаардлагатай сумдын цэцэрлэгийн барилгад засвар хийх буюу шинээр барина.	6.2.5 Сайнцагаан сумын 1-р цэцэрлэг болон шаардлагатай сумдад хүүхдийн цэцэрлэгийн барилга барина.
9	Засаг даргын тамгын газрын конторын барилга /Дундговь, Гурвансайхан сум/	1,200,000,000	5.1.4.4 5 суманд Засаг даргын Тамгын газрын стандартын шаардлага хангасан барилга шинээр барьж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний орчинг сайжруулах	6.1.8 Шаардлагатай сумдын ЗДТГ-ын конторын барилгад засвар хийх болон шинээр барина.	6.2.6 Шаардлагатай сумдын ЗДТГ-ын конторын барилгад засвар хийх болон шинээр барина.
10	Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/	2,000,000,000	-	6.1.5 Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын үргэлжлэл /А, А*, Б, Б*, В блок/ ажлыг дуусгана.	6.2.1 Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгыг дуусгаж ашиглалтад оруулна.
11	Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал сум/	1,000,000,000	3.4.1.5. Гурвансайхан, Говь-Угтаал, Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумдын сургуульд спорт зал, Сайнцагаан сумын "Говийн ирээдүй" цогцолбор сургуульд урлаг зал барих	6.1.11 Шаардлагатай сумдад сургуулийн спорт талбайн тохижилт, заалны барилгыг засварлах буюу шинээр барина.	6.2.9 Сайнцагаан сумын ГИЦС болон шаардлагатай сумдад сургуулийн спорт заалны барилгыг засварлах буюу шинээр барина.
12	Дотуур байрын барилга, 80 ор /Дундговь, Луус сум/	973,000,000	3.4.1.4 Сайнцагаан, Сайхан-Овоо, Луус, Адаацаг сумдад дотуур байр барих	6.1.9 Шаардлагатай сумдын сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгад засвар хийх буюу шинээр барина.	6.2.7 Шаардлагатай сумдын сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгад засвар хийх буюу шинээр барина.
13	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/	1,800,000,000	-	6.1.14 Аймгийн төв болон зарим сумдын төвд хатуу хучилттай зам, тохижилт, ногоон байгууламжийг байгуулна.	6.2.12 Аймгийн төв болон зарим сумдын төвд хатуу хучилттай зам шинээр барьж, засварлан явган хүний зам, талбай байгуулна.
14	Сумын төвийн эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Баянжаргалан сум/	200,000,000	-	6.1.12 Шаардлагатай сумдын нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв барилгад засвар хийх буюу шинээр барина.	6.2.10.Шаардлагатай сумдын эрүүл мэндийн төвийн барилга засварлах буюу шинээр барьж, нэгдсэн эмнэлгийн барилгын сан техникийн засвар, угаалга, моорогийн барилгын их засвар, амбулаторийн барилгын хүзүүвч, хүлээлгийн танхимыг шинээр барина.
15	Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	50,000,000	-	-	-
16	Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж /Дундговь, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум/	250,000,000	-	-	-

17	Сургуулийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	400,000,000	-	6.1.9 Шаардлагатай сумдын сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгад засвар хийх буюу шинээр барина.	6.2.7 Шаардлагатай сумдын сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгад засвар хийх буюу шинээр барина.
18	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	300,000,000	3.4.1.2 Баянжаргалан, Өндөршил, Луус, Эрдэнэдалай, Сайнцагаан, Адаацаг, Дэлгэрцогт, Хулд, Өлзийт сумдад цэцэрлэгийн барилга шинээр барих	6.1.7 Шаардлагатай сумдын цэцэрлэгийн барилгад засвар хийх буюу шинээр барина.	6.2.5 Сайнцагаан сумын 1-р цэцэрлэг болон шаардлагатай сумдад хүүхдийн цэцэрлэгийн барилга барина.
19	Дундговь аймгийн Дэлгэрхангай, Дэрэн сумдын Ерөнхий боловсролын шинэ сургуульд тавилга тоног төхөөрөмж худалдан авах	30,000,000	-	-	-
20	Соёлын төвийн барилга, 240 суудал /Дундговь, Цагаандэлгэр сум/	1,230,000,000	3.5.1.2 Сумдад орон нутаг судлах танхим болон номын сан бүхий иж бүрэн цогцолбор соёлын төвийн барилга барих	6.1.10 Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын ажлыг дуусгаж, шаардлагатай сумдад соёлын төвийн барилгыг засварлах буюу шинээр барина.	6.2.8 Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын ажлыг дуусгаж, шаардлагатай сумдад соёлын төвийн барилгыг засварлах буюу шинээр барина.
21	Дундговь аймгийн Музейд дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмж худалдан авах	40,000,000	-	-	-
22	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 2.8 км /Дундговь, Сайнцагаан сум/	2,200,000,000	-	6.1.14 Аймгийн төв болон зарим сумдын төвд хатуу хучилттай зам, тохижилт, ногоон байгууламжийг байгуулна.	6.2.12 Аймгийн төв болон зарим сумдын төвд хатуу хучилттай зам шинээр барьж, засварлан явган хүний зам, талбай байгуулна.
23	Түргэн тусламжийн автомашин /Дундговь, Өлзийт сум/	35,000,000	-	2.2.2.2 Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглоно.	-

ЦЭЦЭРЛЭГТ ХАМРАГДАЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО

Сумдын нэр	Цэцэрлэг		
	0-5 настай хүүхдийн тоо	Хүчин чадал	Суралцаж байгаа хүүхдийн тоо
Дэлгэрцогт сум	220	90	103
Дэрэн сум	313	100	114
Говь-Устаал сум	194	100	123
Цагаандэлгэр сум	130	50	58
Баянжаргалан сум	183	100	95
Өндөршил сум	146	75	90
Гурвансайхан сум	258	100	110
Өлзийт сум	303	90	105
Хулд сум	305	90	122
Луус сум	239	100	87
Дэлгэрхангай сум	327	100	120
Сайхан-Овоо сум	256	100	100
Эрдэнэдалай сум	857	390	398
Адаацаг сум	387	90	110
Сайнцагаан сум	2390	975	1412
1-р цэцэрлэг		100	205
2-р цэцэрлэг		125	142
3-р цэцэрлэг		160	222
4-р цэцэрлэг		125	185
5-р цэцэрлэг		140	196
6-р цэцэрлэг		125	171
7-р цэцэрлэг		100	134
8-р цэцэрлэг		100	157

СУРГУУЛЬД ХАМРАГДАЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО

Сумдын нэр	6-18 насны хүүхдийн тоо	Хүчин чадал	Суралцаж буй хүүхдийн тоо
Дэлгэрцогт сум	342	160	153
Дэрэн сум	468	320	257
Говь-Угтаал сум	334	320	171
Цагаандэлгэр сум	225	100	92
Баянжаргалан сум	291	240	180
Өндөршил сум	312	320	205
Гурвансайхан сум	461	320	310
Өлзийт сум	509	320	160
Хулд сум	553	320	216
Луус сум	419	240	141
Дэлгэрхангай сум	522	480	413
Сайхан-Овоо сум	494	320	239
Эрдэнэдалай сум	1375	920	1150
Адаацаг сум	637	320	325
Сайнцагаан сум	3509	3844	4484
ЭДЦС		960	1532
ГИЦС		1280	997
Хүмүүнлэг		440	655
Цэгц билиг		204	418
Мандал		960	882

Хавсралт 4

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ХОНОГИЙН СУДАЛГАА

Д/д	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төгрөг/	Гэрээ		Ажил гүйцэтгэх хоног
			Гэрээ байгуулсан огноо	Дуусах огноо	
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Дундговь, Гурвансайхан сум/	1,200.0	2019-05-08	2020-10-30	541
2	Дотуур байрын барилга, 80 ор /Дундговь, Луус сум/	973.0	2019-06-14	2020-08-25	438
3	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Дундговь, Өндөршил сум/	1,000.0	2019-08-21	2020-11-25	462
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум/	1,558.0	2019-08-08	2020-05-29	295
5	Сургуулийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	400.0	2020-05-27	2021-08-20	450
6	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	300.0	2020-05-29	2021-08-20	448
	НИЙТ ДҮН	5,431.0			

Хавсралт 5

ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ АРГА, ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ /ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУГАЦАА/
СУДАЛГАА №1

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Эрх шилжүүлсэн шийдвэр, огноо, дугаар	Үнэлгээний хорооны худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа			
		Эхлэх	Дуусах			ТЕЗ-ийн огноо, дугаар	Байгуулахаар төлөвлөсөн огноо	Байгуулсан огноо	Үүнээс, хэтэрсэн хоног	Эрх шилжсэн хугацаанаас хойш байгуулсан
	А	1	2	3	4	5	6	7	8=7-6	9=7-5
1	Соёлын төвийн барилгын их засвар /Дундговь, Дэрэн сум/	2020	2020	93.0	93.0	2020-02-06	2020-03-05	2020-03-10	5	33
2	Сургуулийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	2020	2021	400.0	200.0	2020-02-06	2020-03-05	2020-03-10	5	33
3	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	2020	2021	300.0	150.0	2020-02-06	2020-03-05	2020-03-23	18	46
4	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар / Дундговь, Сайнцагаан сум, 5 дугаар цэцэрлэг/	2020	2020	20.0	20.0	2020-02-06	2020-03-05	2020-03-12	7	35
5	Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Сайнцагаан сум, 4 цэцэрлэг/	2020	2020	40.0	40.0	2020-02-06	2020-03-05	2020-03-11	6	34
6	Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж /Дундговь, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум/	2020	2020	250.0	250.0	2020-01-21	2020-03-05	2020-03-11	6	50
7	Сумын эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Баянжаргалан сум/	2020	2020	200.0	200.0	2020-02-18	2020-03-05	2020-06-11	98	114
8	Эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Адаацаг сум/	2020	2020	100.0	100.0	2020-02-18	2020-03-05	2020-04-03	29	45

9	Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	2020	2020	50.0	50.0	-	2020-05-25	2020-08-25	92	-
10	Түргэн тусламжийн автомашин /Дундговь, Өлзийт сум/	2020	2020	35.0	35.0	2020-02-11	2020-03-10	2020-03-10	0	28
11	Дундговь аймгийн Дэлгэрхангай, Дэрэн сумдын ерөнхий боловсролын шинэ сургуульд тавилга тоног төхөөрөмж худалдан авах	2020	2020	30.0	30.0	2020-02-21	2020-03-10	2020-03-23	13	31
12	Дундговь аймгийн Музейд дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмж худалдан авах	2020	2020	40.0	40.0	2020-02-21	2020-03-10	2020-03-06	-4	14
13	Дотуур байрны дээврийн засвар /Дундговь, Дэлгэрцогт сум/	2020	2020	27.3	27.3	2020-02-06	2020-03-05	2020-03-10	5	33
НИЙТ ДҮН				1,585.3	1,235.3					

Хавсралт 6

ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ АРГА, ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ /ТЕНДЕРИЙН ХУГАЦАА/ СУДАЛГАА №2

№	Төсөл, хэмжээний арга нэр, чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг /сая.төг рөг/	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа								
		Эхлэх	Дуусах		Тендер							Хүчинтэй байх хугацаа	
					Зарлахаар төлөвлөсөн огноо	Зарласан огноо	Хэтэрсэн хоног	Тендер хүлээж авах эцсийн хугацаа	Үнэлгээний хорооны дүгнэлт гарсан огноо	Харьцуулалт 5 хоног, Нээлттэй 30 хоног дээш хоногт хүлээж авах хугацаа	Тендерт зарцуулсан нийт хугацаа, хоног	Тендерийн хүчинтэй байх хугацаа	Тендерийн хүчинтэй байх хугацааг сунгуулсан эсэх /тийм, үгүй/
	А	1	2	3	4	5	6=5-4	7	8	9=7-5	10=8-7	11	12
1	Соёлын төвийн барилгын их засвар /Дундговь, Дэрэн сум/	2020	2020	93.0	2020-03-09	2020-03-12	3	2020-04-14	2020-04-15	33	1	2020-05-14	үгүй
2	Сургуулийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	2020	2021	400.0	2020-03-09	2020-03-25	16	2020-04-27	2020-05-08	33	11	2020-05-27	үгүй
3	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	2020	2021	300.0	2020-03-09	2020-04-03	25	2020-05-04	2020-05-15	31	11	2020-06-04	үгүй
4	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар / Дундговь, Сайнцагаан сум, 5 дугаар цэцэрлэг/	2020	2020	20.0	2020-03-09	2020-03-13	4	2020-03-24	2020-04-08	11	15	2020-04-24	үгүй
5	Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Сайнцагаан сум, 4 иэиэрлэг/	2020	2020	40.0	2020-03-09	2020-03-11	2	2020-03-20	2020-03-24	9	4	2020-04-20	үгүй

6	Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж /Дундговь, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум/	2020	2020	250.0	2020-03-09	2020-05-05	57	2020-06-05	2020-06-12	31	7	2020-07-05	үгүй
7	Сумын эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Баянжаргалан сум/	2020	2020	200.0	2020-03-09	2020-06-12	95	2020-07-16	2020-07-16	34	0	2020-08-16	үгүй
8	Эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Адаацаг сум/	2020	2020	100.0	2020-03-09	2020-04-08	30	2020-05-12	2020-05-21	34	9	2020-06-12	үгүй
9	Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	2020	2020	50.0	2020-06-10	2020-09-04	86	2020-09-11	2020-09-30	7	19	2020-10-11	үгүй
10	Түргэн тусламжийн автомашин /Дундговь, Өлзийт сум/	2020	2020	35.0	2020-03-12	2020-03-19	7	2020-03-27	2020-03-31	8	4	2020-04-27	үгүй
11	Дундговь аймгийн Дэлгэрхангай, Дэрэн сумдын ерөнхий боловсролын шинэ сургуульд тавилга тоног төхөөрөмж худалдан авах	2020	2020	30.0	2020-03-12	2020-04-03	22	2020-04-13	2020-04-17	10	4	2020-05-13	үгүй
12	Дундговь аймгийн Музейд дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмж худалдан авах	2020	2020	40.0	2020-03-12	2020-04-07	26	2020-04-17	2020-04-21	10	4	2020-05-17	үгүй
13	Дотуур байрны дээврийн засвар /Дундговь, Дэлгэрцогт сум/	2020	2020	27.3	2020-03-09	2020-03-11	2	2020-03-20	2020-04-01	9	12	2020-04-20	үгүй
НИЙТ ДҮН				1,585.3									

Хавсралт 7

ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ / ГЭРЭЭ БАЙГУУЛАХ/ ХУГАЦААНЫ
СУДАЛГАА №3

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг /сая.төгрөг/	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа					
					Гэрээ байгуулах эрх олгох			Гэрээний		
		Эхлэх	Дуусах		Төлөвлөсөн огноо	Эрх олгосон огноо	Үүнээс, хэтэрсэн хоног	Байгуулахаар төлөвлөсөн огноо	Байгуулсан огноо	Үүнээс, хэтэрсэн хоног
	A	1	2	3	4	5	6=5-4	32	33	34=33-32
1	Соёлын төвийн барилгын их засвар /Дундговь, Дэрэн сум/	2020	2020	93.0	2020-04-10	2020-04-21	11	2020-4-21	2020-4-30	9
2	Сургуулийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	2020	2021	400.0	2020-04-10	2020-05-19	39	2020-5-19	2020-5-27	8
3	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	2020	2021	300.0	2020-04-10	2020-05-19	39	2020-5-19	2020-5-28	9
4	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар / Дундговь, Сайнцагаан сум, 5 дугаар цэцэрлэг/	2020	2020	20.0	2020-03-20	2020-04-10	21	2020-4-10	2020-4-22	12
5	Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Сайнцагаан сум, 4 цэцэрлэг/	2020	2020	40.0	2020-03-20	2020-03-31	11	2020-3-31	2020-4-8	8
6	Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж /Дундговь, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум/	2020	2020	250.0	2020-04-10	2020-06-12	63	2020-6-12	2020/06/17	5

7	Сумын эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Баянжаргалан сум/	2020	2020	200.0	2020-04-10	2020-07-24	105	2020-7-24	2020-8-12	19
8	Эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Адаацаг сум/	2020	2020	100.0	2020-04-10	2020-06-03	54	2020-6-3	2020-6-11	8
9	Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	2020	2020	50.0	2020-06-20	2020-09-23	95	2020-9-23	2020-10-7	14
10	Түргэн тусламжийн автомашин /Дундговь, Өлзийт сум/	2020	2020	35.0	2020-03-26	2020-04-07	12	2020-4-7	2020-4-16	9
11	Дундговь аймгийн Дэлгэрхангай, Дэрэн сумдын ерөнхий боловсролын шинэ сургуульд тавилга тоног төхөөрөмж худалдан авах	2020	2020	30.0	2020-03-26	2020-04-28	33	2020-4-28	2020-5-12	14
12	Дундговь аймгийн Музейд дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмж худалдан авах	2020	2020	40.0	2020-03-26	2020-04-28	33	2020-4-28	2020-5-12	14
13	Дотуур байрны дээврийн засвар /Дундговь, Дэлгэрцогт сум/	2020	2020	27.3	2020-03-20	2020-04-03	14	2020-4-3	2020-4-14	11
НИЙТ ДҮН				1,585.3						

НЭМЭЛТ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

/ ГЭРЭЭ СУНГАСАН ХУГАЦААГААР /

Д/д	ТАХ-ний нэр	Анхны гэрээний хугацаа		Нэмэлт гэрээний хугацаа	
		Гэрээ байгуулсан огноо	Дуусах огноо	Гэрээ сунгасан огноо	Дуусах огноо
1	Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/	2019-08-06	2020-10-26	2020.12.28	2021-06-01
2	Засаг даргын Тамгын газрын барилга /Дундговь, Гурвансайхан сум/	2019-05-08	2020-08-28	2020.08.26	2020-10-30
3	Дотуур байрын барилга, 80 ор /Дундговь, Луус сум/	2019-06-04	2020-08-25	2020-08-14	2020-11-25
4	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Дундговь, Өндөршил сум/	2019-08-21	2020-06-30	2020-07-17	2020-08-15
5	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум/	2019-08-08	2019-12-10	2019-12-18	2020-05-29
6	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 2.8 км /Дундговь, Сайнцагаан сум/	2019-06-14	2020-07-10	2020-09-30	2021-06-01
7	Сумын төвийн эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Баянжаргалан сум/	2020-08-12	2020-10-20	2020-10-20	2020-11-30
8	Эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Адаацаг/	2020-06-11	2020-07-31	2020-07-17	2020-08-10
9	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж /Дундговь, Сайнцагаан сум/	2019-09-23	2019-12-02	2019-12-19	2020-07-05

Хавсралт 9

ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ АРГА, ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

№	2020 онд хэрэгжсэн TAX		2020 онд хэрэгжээгүй		2021 онд хэрэгжих	
	TAX нэр	Төсөв /сая төгрөг/	TAX нэр	Төсөв /сая төгрөг/	TAX нэр	Төсөв /сая төгрөг/
1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум/	1,558.0	Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал сум/	1,000.0	Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/	2,000.0
2	Дэлгэрхангай, Дэрэн сумдын Ерөнхий боловсролын шинэ сургуульд тавилга тоног төхөөрөмж худалдан авах	30.0	Дотуур байрын барилга, 80 ор /Дундговь, Луус сум/	973.0	Сургуулийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	400.0
3	Засаг даргын Тамгын газрын барилга /Дундговь, Гурвансайхан сум/	1,200.0	Сумын төвийн эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Баянжаргалан сум/	200.0	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	300.0
4	Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж /Дундговь, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум/	250.0	Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	50.0	Соёлын төвийн барилга, 240 суудал /Дундговь, Цагаандэлгэр сум/	1,230.0
5	Эрүүл мэндийн төвийн их засвар /Дундговь, Адаацаг/	100.0			Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/	1,800.0
6	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Дундговь, Өндөршил сум/	1,000.0			Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж /Дундговь, Сайнцагаан сум/	300.0
7	Дотуур байрны дээврийн засвар /Дундговь, Дэлгэрцогт сум/	27.0				
8	Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Сайнцагаан сум, 4 цэцэрлэг/	40.0				
9	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар /Дундговь, Сайнцагаан сум, 5 дугаар цэцэрлэг/	20.0				
10	Соёлын төвийн барилгын их засвар /Дундговь, Дэрэн сум/	93.0				
11	Дундговь аймгийн Музейд дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмж худалдан авах	40.0				

12	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 2.8 км /Дундговь, Сайнцагаан сум/	2,200.0				
13	Түргэн тусламжийн автомашин /Дундговь, Өлзийт сум/	35.0				
НИЙТ ДҮН		6,593.0	-	2,223.0	-	6,030.0

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ᠓ᠨ